



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙДЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, оны шилдэг байгууллага, инженер, техникийн ажилтан шалгаруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ журамд заасны дагуу Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, оны шилдэг байгууллага, инженер техникийн ажилтныг жил бүр шалгаруулж, үйл ажиллагааг нь сурталчлах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Цогтсайхан/-т даалгасугай.
3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд үүрэг болгосугай.



151010850

Барилга, хот байгуулалтын сайдын  
2021 оны 11 дугаар сарын 15 өдрийн  
дугаар тушаалын хавсралт

ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХҮЙН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ, ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА, ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН  
АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

**Нэг. Ерөнхий зүйл.**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь салбарын хэмжээнд орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын тухайн жилийн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээгээр нь ангилан үнэлгээ өгөх, урамшуулах, туршлага солилцуулах, үйл ажиллагаанд гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, эдгээртэй холбоотой мэдээллийн сан үүсгэх, үнэлгээ, шинжилгээ, судалгаа хийхэд оршино.

**Хоёр. Хамрах хүрээ.**

- 2.1. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын оны шилдэг байгууллагын шалгаруулалтад орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалт, үйлчилгээний чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан бүх байгууллагууд заавал хамрагдсан байна.
- 2.2. Үнэлгээнд хамрагдах байгууллагуудыг дараах байдлаар ангилна. Үүнд:
  - 2.2.1. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд;
  - 2.2.2. Улаанбаатар хотын хувийн хэвшлийн орон сууцны ашиглалтын байгууллагууд;
  - 2.2.3. Аймгийн төвүүдийн орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагууд, үйлчилгээний цар хүрээн нь аймгийн төвийн нийтийн аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээтэй дүйцүүлж үзэж болох томоохон сумын нийтийн аж ахуйн байгууллагууд /ажлын хэсэг энэ хэсэгт хамрагдах сумын нийтийн аж ахуйн байгууллагыг хэлэлцэж тогтоно./;
  - 2.2.4. Сумын төвийн нийтийн аж ахуйн байгууллагууд.

**Гурав. Байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх ажлын зохион байгуулалт**

- 3.1. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын шилдэг байгууллагуудыг дараах үзүүлэлтүүдээр нэгтгэн дүгнэж, шалгаруулна. Үүнд:
  - 3.1.1. Тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлт, шалгуур үзүүлэлтийн нэгдсэн үнэлгээ, дүгнэлт /Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн үнэлгээ, дүгнэлтээр/;
  - 3.1.2. Орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалт, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн үнэлгээ болон инженер, техникийн ажилтны энэ журмын 5.2 дах заалтанд заагдсан үзүүлэлтүүдийг дүгнэсэн үнэлгээ /"Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын Нийтийн аж ахуйн хэлтсийн үнэлгээгээр/;
  - 3.1.3. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын гурван талт хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт /Монголын Орон сууц,

нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны үнэлгээгээр/.

- 3.2. Үнэлгээ өгөх байгууллагууд 1-100 хүртэл хувьчилан дүгнэж байр эзлүүлэх ба ангилал тус бүрээр эхний 3 байр эзэлсэн байгууллагуудын ажлын үр дүнгийн мэдээлэл, үр дүнд хүрсэн бүтээлч ажил, бусад байгууллагуудад түгээн дэлгэрүүлэх туршлага, шинэ санаачлагын талаарх мэдээллийн хамт, сүүлийн байр эзэлсэн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулсан байна.
- 3.3. Үнэлгээ хийсэн байгууллагууд нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчид үнэлгээг танилцуулсан байна.
- 3.4. Үнэлгээг хийхдээ орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалт, үйлчилгээ хариуцсан тусгай зөвшөөрөлтэй бүх байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулсан байна.
- 3.5. Байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөв үнэлсэн байна.
- 3.6. Үнэлгээг хийх байгууллагууд нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх материалыг дараа оны 02 дугаар сарын 20-ны дотор хүлээн авч, 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэж, холбогдох материалуудын хамт 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлнэ.

#### **Дөрөв. Шалгаруулалтын үйл ажиллагаа**

- 4.1. Энэ журмын 2.2 дахь заалтын дагуу ангилал тус бүрээс дараах байдлаар шалгаруулна. Үүнд:
  - 2.2.1. ангиллын хүрээнд 1 байгууллага;
  - 2.2.2. ангиллын хүрээнд 3 байгууллага;
  - 2.2.3. ангиллын хүрээнд 3 байгууллага;
  - 2.2.4. ангиллын хүрээнд 3 байгууллага.
- 4.2. Мөн ангилал тус бүрээс салбартаа шинэ техник, технологи нэвтрүүлсэн, шинэ санаачлага гаргасан, зардал бууруулсан, тэдгээрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж үр дүнд хүрсэн ажлаар нь 1 инженер, техникийн ажилтныг шалгаруулна.
- 4.3. Энэ журмын хавсралтаар байгуулагдсан ажлын хэсэг нь 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хуралдан байгууллагуудын үнэлгээг нэгтгэн дүгнэж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулна.
- 4.4. Үнэлгээ, дүгнэлт хийгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор шалгаруулалтыг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталгаажуулж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, биелэлтийг хангаж ажиллана.
- 4.5. Дээрх шалгарсан 10 байгууллагыг Барилгын салбарын оны шилдэг байгууллага шалгаруулахад нэр дэвшүүлж, оролцуулна.

#### **Тав. Үйл ажиллагааг үнэлэх аргачлал**

- 5.1. Тухайн байгууллагуудын үнэлгээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, Монголын Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны

үйлдвэрчний эвлэлийн холбооноос дүгнэж ирүүлсэн үзүүлэлтүүдийн дунджаар хувьчлан онооны дарааллаар ангилал бүрээр байр эзэлүүлнэ.

- 5.2. Инженер, техникийн ажилтныг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Үүнд:
- а. Тухайн инженер, техникийн ажилтны нэвтрүүлсэн шинэ техник, технологи, гаргасан шинэ санаачлага болон зардал бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил нь байгууллагын үйл ажиллагаанд нэвтэрсэн байдал;
  - б. Хэрэглээнд нэвтэрч хэрэглэгчдэд хүрсэн байдал;
  - в. Эдийн засгийн үр ашгийн тооцоолол;
  - г. Цаашид туршлага болон нэвтрүүлэх боломжтой эсэх.

#### **Зургаа. Шагнал, урамшуулал**

- 6.1. Тухайн онд ажлын үзүүлэлтээр шалгарсан байгууллагыг Барилга, хот байгуулалтын сайдын Батламж, Шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнаж, урамшуулна.
- 6.2. Шалгарсан инженер, техникийн ажилтныг Барилга, хот байгуулалтын сайдын Батламж, мөнгөн шагналаар шагнаж, урамшуулна.
- 6.3. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, Монголын Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо нь байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн үнэлгээндээ тулгуурлан шагнал, урамшуулал олгож болно.
- 6.4. Ажлын хэсэг нь шалгарсан байгууллагуудын танилцуулга, ажлын амжилтых зэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээх, үр дүнд хүрсэн ажлын туршлагыг салбарын байгууллагуудад таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулна.

#### **Долоо. Бусад**

- 7.1. Үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж авсан байгууллагуудад зөвлөмжийн дагуу төлөвлөгөөт ажил зохион байгуулж, биелэлтийг ирүүлэх хугацаат үргийг Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулна.
- 7.2. Тухайн оны шилдэг байгууллага нь дараагийн оны шилдэг байгууллагад шилжин явах цом гардуулах арга хэмжээ зохион байгууллагдахаас 2 хоногийн өмнө ажлын хэсгийн нарийн бичгийн даргад шилжин явах цомыг хүлээлгэн өгсөн байна.

“Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх, оны шилдэг байгууллага, инженер, техникийн ажилтан шалгаруулах журам”-ын хавсралт

**ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ, ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА, ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч.

Гишүүд:

- Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч;
- Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хот, суурины бохир ус цэвэрлэх байгууламжийн технологи, ашиглалт үйлчилгээ хариуцсан шинжээч;
- Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Орон сууцны ашиглалт, үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн;
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Захиргаа, удирдлагын газрын дарга;
- “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Нийтийн аж ахуйн хэлтсийн дарга;
- Монголын Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга;
- Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын эрх зүйн зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн.

---оOо---